

НАГ., Х-1, Д-1, ХН-1315

**ЦАГДАН СЭРГИЙЛЭХИЙН ХӨРӨНГӨНИЙ ДҮРЭМ, ХОРИХ ГАЗРААС ОРГОСОН
ЯЛТНЫГ ЗАРЛАСАН ГАЗРЫН ИЛТГЭЛ ЦАЛИНГИЙН ХҮСНЭГТ, ШАГНАХ
ХҮМҮҮСИЙН БАРИМТ**

**УЛААНБААТАР ХОТЫН ЦАГДАН СЭРИЙЛЭХ ГАЗРЫН ТУСГАЙ ХӨРӨНГӨНИЙ
ДҮРЭМ**

- 1) Тусгай хөрөнгөний тухай дүрмийн ёсоор Улаанбаатар хотын цагдан сэрийлэх газар тусгай хөрөнгө байгуулж болмуй.
- 2) Хотын цагдан сэргийлэх газрын тусгай хөрөнгийг ямар зүйлүүдээс хэчнээн таслан гаргаж байгуулахыг тодорхойлбоос:
 1. Баригдсан малуудыг худалдаж авсан үнэ мөнгөний 100 хувийн 50 хувь,
 2. Хулгайд автсан буюу алдагдсан бөгөөд олдсон зүйлүүдийн бүх үнийн 100-ны арван хувиар тогтоож уул зүйлүүдийг эздэд шилжүүлэн өгөх дахин хураан авах болмуй.
- 3) 2 дугаар зүйлд дурдсан тусгай хөрөнгийг ямар зүйлд зарцуулахыг тодорхойлбоос:
 1. Хувцас сайжруулах
 2. Зэвсгийг зузаатгах
 3. Харилцан нэвтрэлцэх хүчийг сайжруулах
 4. Баригдсан малуудыг хамгаалан хадгалах тухай зарлага болмуй.
- 4) Энэхүү дүрэмд дурдсан тусгай хөрөнгийг монгол банкны газраа харилцах данс нээн хадгалж чинээгээр зарцуулах болмуй.
- 5) Хотын цагдан сэргийлэх газар нь дүрэм зааврын ёсоор тусгай хөрөнгийн орлого зарлагыг санхүүгийн явдлыг эрхлэх газраас хянуулах болмуй.

21 он 4 сард засгийн газрын эрхлэх товчооны 15 дугаар хурлын тогтоолын 2-т баталжээ.

Цагдан сэргийлэх 33 суман 35 ангид эдүгээ төв засан сайжруулах газраас тус газраа хоригдон баригдан ялтан нараас удаа дараа оргогсдын зарим нь биеийн байдал зэргийг тодорхойлж байцаан бариулах учрыг урьд зохих газруудад явуулсан боловч одоо хүртэл бариулан ирсэн газаргүй бөгөөд одоо уг оргогсдын овог нэр захиргаа үйлдсэн гэмт явдал хоригдох хугацаа хэмжээ хэрхэн оргогсныг хойно жагсааж явуулах нь газрууд ба ард түмэнд нийтээр зарлах зэргээр гүйцэтгэж эдгээр оргогсдыг эрх биш даруйхнаа дачлан бариулж хүргүүлэн ирүүлмүй хэмээсэн үүнийг жагсаалтын хэвээр жагсааж эдгээр дээр дурдсан ёсоор доор жагсагсдыг даруй түргэнээ дайчлан бариулж хүргүүлэн ирүүлэх зэргээр гүйцэтгүүлсээр үүнийг цагдан сэргийлэхээс нэгэн адил явуулъя.

Дарга:Цэвдэн

Нарийн бичгийн дарга чухал эрхэлсэн: Чойнжун

ЖАГСААСАН:

1. Газар тариалангийн аймгийн мөнгөний хэрэгт 2 жил 6 сар хоригдох ял олсон бутач Дэмчиг энэ он 7 сарын ..-ны өдөр түр чөлөөгөөр яваад оргожээ.
2. Архангай аймгийн хувьсгалт тэрслэгч хэрэгт 5 жил хоригдох ял олсон Самдангийн бүхий 7 сарын хорин дөрвөнд хорих газрын хашаагаар давж оргожээ.
3. Хэнтий аймгийн дээрмийн хэрэгт 10 жил хоригдох ял олсон 8 сарын 19-нд хорих газрын хаалгаар оргожээ.
4. Хотын жинхэнэ харьяат хулгайн хэрэгт ... жил 7 сар хоригдох ял олсон бутач Хонгоржав 8 сарын 10-нд наран хэмээх газар хорьж албадан ажил үйлдэхүй хэмээгч бүхийд оргожээ.
5. Хөвсгөл аймгийн хулгайн хэрэгт хоригдох ял олсон бутач Наранчүлтэм 8 сарын ..-ны өдөр мөн хадлангиын газраас оргожээ.

6-10 үртэл дутуу

11. Богд хан аймгийн хувьсгалд тэрслэсэн хэрэгт 5 жил хоригдох ял олсон Гэндэн ... 8 сарын 27-нд мөн газраас оргожээ.

12. Мөн аймгийн дээрмийн хэрэгт 10 жил хоригдох ял олсон Лүндэнгийн 8 сарын ..-нд хорин газраас оргожээ.

13. мөн аймгийн адил хэрэгт ял олсон Моломын Намсрай мөн өдөр хамтаар оргожээ.

14. төв аймгийн цэргийн сахилга журмыг гажуудуулсан хэрэгт 8 сар хоригдох ял олсон Гомбодоржийн Дашзэвэг 9 сарын 7-нд Богд уулын модны дэргэд хорьж албадан ажил хийлгэж бүхийд оргожээ.

15. СССР-ийн харьяат албаны төгрөгт эс гүйцэтгэсэн хэрэгт 5 сарын хоригдох ял олсон Базарын 9 сарын 10-нд мөн газраас оргожээ.

16. Богд Хан аймгийн хувьсгалд тэрслэсэн хэрэгт 7 жил хоригдох ял олсон Дагвын Цэдэвдорж 9 сарын 8-нд тус ... дахь манай арьс ширний заводын дэргэд хорьж албадан ажил хийлгэж бүхийд оргожээ.

17. Мөн аймгийн адил хэрэгт 5 жил хоригдох ял олсон Тогоогийн Жамбалдорж мөн газраас хамт оргожээ.

18. Цэцэрлэг аймгийн хулгайн хэрэгт 3 жил хоригдох ял олсон Дуламжавын Дашням 9 сарын 15-нд Богд уулын модны дэргэд хорьж албадан ажил хийлгэж бүхийд оргожээ.

19. Мөн аймгийн цэргийн сахилга батыг гажуудуулсан хэрэгт 8 сар хоригдох ял олсон Сэрбэнтэйгийн Лувсанхүү 9 сарын 21-нд хорих газраас оргожээ.

20. Хэнтий аймгийн хулгайн хэрэгт 9 жил 7 сар хоригдох ял олсон Цэвэгийн Зундуй 9 сарын 25-нд мөн хорих газраас оргожээ.

21. Төв аймгийн цэргээс оргосон хэрэгт 8 сар хоригдох ял олсон Ишдэндэвийн Төвдөн..... 9 сар ..-нд тус хот дахь манай арьс ширний газар хорих албадан ажил хийлгэж бүхийд оргожээ.

22. Богд Хан аймгийн дээрмийн хэрэгт 10 жил хоригдох ял олсон Балдангийн буриад Баяр 9 сарын 30-нд Тэрэлж хэмээх газар хорьж албадан ажил хийлгэж бүхийд оргожээ.

23. Богд Хан аймгийн дээрмийн хэрэгт 7 жил хоригдох ял олсон Цэвээний Очир өдөр тус газраас оргожээ.

24. СССР-ийн харьяат дээрмийн зэрэг олон ... хэрэгт 10 жил хоригдох ял олсон Аюушийн Санчимэдов 10 сарын ...-нд Тэрэлж хэмээх газар хорьж албадан ажил хийлгэж бүхийд оргожээ.

25. Цэцэрлэг аймгийн улсаас урвасан хэрэгт 1 жил 6 сар хоригдох ял олсон Шагдарын Дамба мөн өдрөө Мухар хэмээх газраа хорьж албадан ажил хийлгэж бүхийд оргожээ.

26. Хэнтий аймгийн хувьсгалд тэрслэсэн хэрэгт 5 жил хоригдох ял олсон Эрэгзэнгийн Бусүрэн мөн өдөр тус газраас оргожээ.

27. Цэцэрлэг аймгийн цэргээс оргосон хэрэгт 3 жил хоригдох ял олсон Дэндэв 10 сарын 1-нд Богд хан уулын модны дэргэд албадан ажил хийлгэж бүхийд оргожээ.

28. Богд Хан аймгийн ... юм ашигласан хэрэгт 2 жил хоригдох ял олсон Сүхийн Дарь мөн өдөр тус хот дахь манай арьс ширний заводын дэргэд хорьж албадан ажил хийлгэж бүхийд оргожээ.

29. Төв аймгийн хулгайн хэрэгт 6 сар хоригдох ял олсон Чүлтэмийн урт шар хэмээх Ишжамц 10 сарын 10-нд тус газраас оргожээ.

30. Өвөрхангай аймгийн хувьсгалд тэрслэсэн хэрэгт 8 жил хоригдох ял олсон Самбуугийн Дамдин 10 сарын ..-нд тус хот дахь манай арьс ширний заводын дэргэд хорьж албадан ажил хийлгэж бүхийд оргожээ.

31. Цэцэрлэг аймгийн тусгай комиссоос 10 жил хоригдох ял олсон Лувсангийн Баасан мөн өдөр мөн газраас оргожээ.

32. Мөн аймгаас урвасан хэрэгт 5 жил 1 сар хоригдох ял олсон Борын Самдан 10 сарын 25-нд мөн газраас оргожээ.

33. Мөн аймгийн тусгай улсаас 3жил хоригдох ял олсон Санжийн Дэмэдбаатар 7 сарын 39-нд тус газраас оргожээ.

34. Хотын жинхэнэ харьяат хулгайн хэрэгт .. жил хоригдох ял олсон Чүльэмийн Цэрэндорж 10 сарын 27-нд Төв аймгийн шүүх авчирсанд оргожээ.

35. Хулгайн хэрэгт 1 жил 1 сар хоригдох ял бутач Бямба .. сарын 27-нд оргожээ.

36. Мөнгө ашигласан хэрэгт 3 жил 3 сар хоригдох ял олсон Лувсангийн Дэмбэрэл .. сарын 11-нд оргожээ.

37. Хотын жинхэнэ харьяат хулгайн хэрэгт 1 жил 6 сар хоригдох ял олсон Доржийн Банзрагч 11 сарын 7-нд оргожээ.

ХОРИН НЭГДҮГЭЭР ОН ТАВАН САРЫН АРВАН ТАВАН

ЦАГДАН СЭРГИЙЛЭХ ГАЗРЫН ИЛТГЭЛ

Тус Улаанбаатар хотын ба эргэн тойрин арван таван модны газар суугаа ард түмэн нь амгалан тайван хэвийг хамгаалан сэргийлж байгаа үүнд эдгээр ардуудын хөрөнгө хогшлыг ил нууцаар дээрэмдэн хулгах буюу амь биеийг буу зэвсэг барьж бусниулах худал цуурхал гаргаж олон нь сэтгэлийг үймүүлэх мөн албаны газрын нэр сүрийг барин явж бусдыг хуурмаглан мэхэлж татвар түрээс хурааж төгрөг мөнгө ашиглах ба энгийн суугаа ардын эрх чөлөөнд шууд халдаж нэгжих хэзэр даалуу маажан буу номер зэрэг мэдэх мэдэгдэхгүй наадам тоглоомыг гаргаж үлэмжхэн мөрийтэй тоглож олон хуралдсан ажилчин ардын хөлс мөнгийг хураан авах бие биесийг тонож мөлжих хар тамхи татах ба бусдад их үнээр зарж архи ууж хэтэрхий согтууран албаны газар ба энгийн хүмүүсийг авирлан загнаж зүй бусаар хэв сувдлыг зөрчиж эд хогшлийг эвдлэн сүйтгэх уурын тэрэгний жолооч нар болбоос тогтоосон дүрэм хэмжээнээс гажуу сөргөн довтлон явж хүнийг амь биеийг дайруулан хорлох хашаа байшин дугуй зэргийг нэгэн адил эвдлэх үүнд тус газрын цөөн орон тооны албан хаагчид бүгдээр ард олны тайван хэвийг хамгаалж элдэв зүйлийн эрүүгийн хэрэг өдүүлэгчид лүгээ эсэргүүцэн тэмцэж эрин сурвалжлах явдлыг өдөр шөнийн 24 цагт үргэлжлэн явж сэдэвлэн олж заримыг нь шүүх таслах газар шилжүүлэх буюу тус газрын эрх хэмжээнд багтах хэргүүдийг албадан ажил үйлдвэр хийлгэх төгрөгөөр торгож ухуулан донгодох зэргээр дуусгаж гүйцэтгэн буй боловч цөөн тооны цагдаа нар элдэвд үл хүрэлцэх ба цагдаагийн үүрэг зорилгыг таньж мэдсэн этгээд нэн ховрын дээр эрүүгийн хэрэг өдүүлэгчид болбоос туйлын чадамгай боловсоргосон аймшиггүй түрэмгий этгээдүүд олонтоо төрж эвлэлдэн бүлэглэж үйлдэх учир аливаад үл хүрэлцэн ажил хэрэгт дутагдалтай зүйлүүд тун ч их гардгаас эдүгээ хүртэл зарим хэрэгтнийг огт олж мэдээгүй зүйл ч байна жишээлбээс, сүүлийн үед болсон бугаар буюу сүх мод төмөр зэрэг зэвсэг багажаар хэд хэдэн хүнийг амь хорлож морь уналгыг авч одсон ба төгрөг мөнгийг дээрэмдэн олгосон этгээдүүдийг олж чадаагүй болой түүнээс гадна гол ихээхэн хүчтэй этгээд болох Улаан хэмээн Дагва нарын зэрэг нэлээд хүмүүсийг баримттай холбогдох хэрэгт баривчлан авч зохих газар шилжүүлэн байцаалгаж байна. Хорин нэгэн он нэгэн сарын нэгнээс эхлэн таван сарын арван тавны өдөр хүртэл тус газар хүлээн авсан эрүүгийн хэрэг 648 болохоос хууль ёсоор зохих газар шилжүүлсэн хэрэг 314 тус газрын эрх хэмжээний

ёсоор таслан шийтгэсэн эрүүгийн хэрэг 334 болохоос үл дагаж хотын захиргааны зөвлөлд давж заалдсан хэрэг хоёр болох үүнд:

Засаг захиргаанд тэрслэсэн хэрэгтэн 80 шүүх таслах явдалд тэрслэсэн хэрэгтэн 26 ард олны эрүүлийг хамгаалах тухай дүрмийг зөрчсөн хэрэгтэн 149 ард олны хэв суртлыг зөрчсөн хэрэгтэн 144 албаны хүмүүс гэмт хэрэг явдлаар явсан хэрэгтэн 17 хүнийг амийг хорлосон хэрэгтэн 17 хулгах булаах дээрэмдэх зэрэг бусдын эд хөрөнгийг сүйтгэсэн хэрэгтэн 254 болмуй.

Мөн эл хэрэгт холбогдон мөрийцөн наадсан буюу хар тамхи татсан ба худалдсан уурын тэргээр бусдыг дайруулсан зэрэг зүй бус гэмт хэрэг өдүүлэгчид лүгээ эсэргүүцэн тэмцэх явдалд тус газрын орон тоо туйлын тутмаг болох үүнд, 28 жинхэнэ цагдаа байгаа боловч зогсох манаа буюу эргүүлд явах нь дэвсгэр газрын хэмжээнд үнэхээрийн дутагдалтай болох учир эрхбиш хороо бүрт нэгэн шөнө гурван цагдаагаас доогшүй эргүүлийг гаргаваас аливаад нэлээд дөхөмтэй ба үүний урьд улаан цэргээс олон хороодын дэвсгэр газраар гарч байсан эргүүлийг татаж буулгасан явдал болбоос манай ажилд ихээхэн нэмэгдэл гарсан байгаа үүгээр барахгүй уналгын нэгэн зүйл болбоос төдийлөн гаслалтай бус болох ба эргүүлийн цагдаа нарт дугуй олгосон авч голгүй уул модны зэрэг газар морьтой явган этгээдийг үзмэгц барих довтолгох хэрэгт дөхөмгүй болмуй учир юунаас хэмээвээс хэдэн хэдэн удаа улаан цэргийн зэвсэг ба бинзений газар зогссон харуул манааны цэргийн шархдуулан буудаж морьтой зугтсан этгээдийг нүд үзсэн боловч аргагүй алдаж ирснээс илэрхий болно.

Тус газрын цагдаа нарт болбол ер амралтын цаггүй үргэлж яван ядарч зүдрэх явдал нэн их болохын дээр цагдаагийн үүрэг зорилгыг дүүрнээ танигтун. Цагдаа нарт гол хүч үндэс болох бэлтгэлтэй этгээд ч туйлын тутмаг ба нам эвлэлийн хотын хороод үйлдвэрчний төв зөвлөлөөс итгэмжилсэн үнэмлэх бүхий гишүүн этгээдийг авч буйгийн дотор цэргийн сургууль үйлдсэн чадвар бүхий хүмүүс буюу зэвсгийг бүрэн дүүрнээр хэрэглэн чадах этгээд цөөн байгаа учраас аль нэгэн эргүүл манааны зүйлд алдаатай явдал үргэлж үзэгдсээр байдаг ийм байдлыг дахин давтан хэлсээр байвч зарим үл бүтэх этгээд нараас эцсийн үед өөрсдөө хулгай хийж баригдан зохих газар шилжсэн зүйл байна. Үүнд санахад эрхбиш хот суурин газрыг цагдах хамгаалах явдалд бэлтгэл сургууль бүхий этгээдийг үйлтгүүлэн авч гүйцэтгэвээс уг ажил хэрэгт туйлын дөхөмтэй болмуй. Энэ 21 он гарснаас хоршооны хотын хэлтэс шинэ барилгын газар монгол хэвлэлийн хороо зэрэг газрууд лугаа тусгай гэрээ хэлэлцээгээр тус тусын газруудад бусад цагдаа нарыг анги хуваан томилон суулгаж одоо гэрээ хэлэлцээний ёсоор томилон авсан цагдаа 56 хүн болно. Тус цагдан сэргийлэх газрын Андерсан хэмээх хотын доторх аливаа хүмүүсийг бүртгэх тасгийн хэрэг ажил эдүгээ хүртэл хөтөлж цагдаагүй бөгөөд саяхан уг үйлтгэх данс маяг зааврыг гаргаж өгсөн ба эрхлэх дарга бичээч хоёр өөрсдийн сайн дураар цалин хэрэглэлийг хэвээр авч тариалангийн ажлаар хөдөө яваад эгэж ирээгүй тул эрхлэх этгээд нарыг шаардан ирүүлж уг хэргийг хөтөлгөн явуулахыг оролдон байна. Ер

тус газрын сургагчийг өөр газрын сургагч лугаа хавсруулснаас аливаа нэгэн хэрэгт чирэгдэлтэй буюу дутагдалтай зүйл олонтоо гардаг учир эрхбиш тусгай сургагч суулгаваас хэрэг ажилд ихээхэн дөхөмтэй ба элдэв эрүүгийн хэргийг арга эрж олох нууц бүлгэмгүй болох нь хэрэгтэн этгээдийг хэдхэн цагдаа нар эрж сурвалжлан олдоход үнэхээрийн дутагдалтай зүйлийн нэгэн нь даруй мөн амуй. Иймд эл бүлгэмийг байгуулж эрүүгийн хэрэг өдүүлэгчдийг эрж олох хүмүүсийг бэлтгэвээс энэхүү үргэлжлэн гарч байгаа үл бүтэх тайвангүй түгшүүртэй ажилд үнэхээр дөхөмтэй болмуй.

Жич тус цагдан сэргийлэх газар энд тэндээс баригдан ирсэн алдуул адуу тэмээ үхэр хонийг он жил удтал хадгалж олон удаа зарласан боловч уул эзэд энэ завсар танин аваагүй болох тул одоо даруй үнэ тогтоон эзэд нь үл олдох малуудыг зохих газар харилцан худалдахыг завдан буй ба 21 оны нэгэн сараас дөрвөн сарыг хүртэл эзэд үгүй баригдан ирсэн толгой малууд бүгд 14 болохыг хуучин малуудын хамтаар тусгай хүнд хөлс өгч хадгалуулан байгаа болой.

Хийхийн анкет ариун цэврийн хэрэг ажлыг эрхбиш аятай цэвэр байлгахыг олон ангийн ардуудад үргэлж хийлгэсээр буюу уух усыг буртаггүй газраас авахуулахыг оролдсоор ирсэн боловч төдийлөн чанарыг олж яваагүй амуй. Тус хотын дотор их бага галын аюул энэ 21 он нэгэн сараас дөрвөн сарын хорин нэгний өдөр хүртэл гучин таван удаа гарсны тухайд зохих газрууд лугаа хүчин хавсран дарсаар байсан боловч эвлэлийн төв хороонд гарсан нэгэн удаагийн галыг унтраан чадсангүй бүрмөсөн шатаасан учир болбоос усан хөөрөгний усны сав хоёр тэргээс өөр бэлтгэлгүйд ихээхэн галд хүчин үл хүрэлзэх явдал нэлээд гарсаар ирснийг дээр энэхүү галд мөн усны сав багаас дийлсэнгүй болой.